



Танилцуулга N°2

Хорих газарт эрүү шүүлтээс сэргийлэх мониторингийн хүрээнд ярилцлага хийх хүмүүсийг хэрхэн сонгох тухай

Эрүү Шүүлтээс Урьдчилан Сэргийлэх Нийгэмлэг (ЭШУСН) 1977 онд байгуулагдсан цагаасаа хойш хорих газруудад эрүү шүүлт болон бусад хэлбэрээр хэрцгий хандах явдлаас сэргийлэх үр дүнтэй арга бол тэдгээрт бие даасан, тогтмол мониторинг хийх явдал мөн хэмээн үзэж, түүнийг дэмжсээр ирсэн билээ. “Хорих газрууд дахь мониторинг” хэмээх цуврал удирдамжид ЭШУСН-ээс хийсэн судалгаа шинжилгээ болон манай түнш байгууллагуудаас дэлхий даяар үндэсний хийгээд олон улсын төвшинд ашиглаж байгаа тэргүүн туршлагыг багтаасан. Энэ нь ЭШУСН-ээс өмнө нь эрхлэн хэвлүүлсэн “Хорих, цагдан хорих газарт хийх мониторинг: ТББ-уудад зориулсан аргачилсан удирдамж” номонд хөндсөн асуудлыг илүү нарийвчлан авч үзэх зорилготой юм.

Цуврал удирдамжтай холбоотой аливаа санал шүүмжээ apt@apt.ch хаягаар ирүүлэхийг хүсье.

2009 оны 4-р сар

Хорих газарт эрүү шүүлтээс сэргийлэх мониторингийн хүрээнд ярилцлага хийх хүмүүсийг хэрхэн сонгох тухай

1. Энэхүү удирдамжийг хэрхэн ашиглах тухай

Энэхүү баримт бичгийг эрүү шүүлт болон бусад хэлбэрээр хэрцгий хандах явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор хорих газруудад мониторинг хийж байгаа болон хийхээр төлөвлөж байгаа байгууллагуудын хэрэгцээнд зориулан боловсруулав. Удирдамжийг мониторингийн ерөнхий стратегийг боловсруулах, засварлах буюу хорих газарт очихоос өмнө ярилцлагын стратегийн талаар мэдээлэл өгөх зорилгоор ашиглаж болно. Анхаарал хандуулах гол асуудал бол эрх чөлөөгөө хасуулан хоригдож байгаа хүмүүсээс ярилцлага хийх хүмүүсээ хэрхэн сонгох явдал юм. Гэхдээ уг удирдамж нь мониторинг явуулж байгаа байгууллага, хүмүүсийн авч хэрэгжүүлэх алхам бүрийг заасан зааварчилгаа биш бөгөөд харин тэдэнд үйл ажиллагааныхаа үр дүнг дээшлүүлэхэд ашиглаж болох төрөл бүрийн хувилбар, чухал асуудлыг багтаасан баримт бичиг юм. Ярилцлага хэрхэн явуулах тухай дэлгэрэнгүй мэдээллийг ЭШУСН-ээс эрхлэн хэвлүүлсэн “Хорих, цагдан хорих газарт хийх мониторинг: ТББ-уудад зориулсан аргачилсан удирдамж” номноос үзнэ үү.

2. Нэн тэргүүнд анхаарах зүйлс

Эрх чөлөөгөө хасуулан хоригдож байгаа хүмүүсээс ганцаарчилсан ярилцлага авах нь хорих газарт эрүү шүүлтээс сэргийлэх зорилгоор хийх мониторингийн чухал бүрэлдэхүүн хэсэг мөн. Энэ нь тэдгээр хүмүүсээс “газар дээрээс нь” мэдээлэл авах төдийгүй мөн тэдэнд санасан бодсоноо хуваалцах боломж олгодог. Ийм ярилцлага нь тухайн хорих газарт оршиж байгаа хүний эрхийн зөрчлийг олж илрүүлэхэд нэн чухал үүрэг гүйцэтгэдэг.

Үр дүнтэй мониторинг хийхийн тулд тодорхой тооны хоригдлоос ярилцлага авах шаардлагатай. Мониторинг явуулдаг зарим байгууллага тухайн хорих газрын талаар хангалттай мэдээлэл авахын тулд нийт хоригдлын 5%, 10%, эсхүл бүр 20%-иас ярилцлага авах ёстой гэж үздэг боловч энэ нь тийм амар хэрэг биш юм. Учир нь нэг хорих газар хэдэн зуу, тэр ч бүү хэл хэдэн мянган хоригдолтой байх нь олон тохиолддог. Тиймээс, мониторинг хийгчид хязгаарлдагдмал хүн хүч, материаллаг болон цаг хугацааны хүчин зүйлсийг хэрхэн үр дүнтэй ашиглах талаар төвөгтэй шийдвэр гаргах хэрэгтэй болдог. Чухам тийм учраас ярилцлага хийхэд тохирох стареги баримтлах шаардлага тавигддаг билээ.

Аль нэг тодорхой стратегийг сонгохоосоо өмнө бодлогын чанартай дараахи өргөн хүрээтэй асуудлыг эргэцүүлэн үзэх нь чухал.

Багийн бүрэлдэхүүн

Мониторинг хийх байгууллагын нөөц бололцоо, тухайн хорих газрын хэмжээ зэргээс хамаарч мониторинг хийх багийн гишүүдийн тоог аль болох олон байхаар бүрдүүлэх нь чухал. Энэ нь багийн гишүүд дэд бүлэгт хуваагдан, нэгэн зэрэг ажиллах боломж олгодог. Ингэснээр тухайн хугацаанд аль болох олон ярилцлага авах боломж бүрддэг.

Ганцаар болон хосоор ярилцлага авах

Мониторинг хийдэг олон байгууллага хосоор буюу хоёр хүн ярилцлага авах хэлбэрийг түлхүү хэрэглэдэг. Багийн нэг гишүүн асуулт асууж, ярилцлага авч байхад нөгөө нь түүнийг тэмдэглэж авна гэсэн хэрэг. Энэ арга нэлээд давуу талтай боловч зарим байгууллага туршлагатай мониторингчдод ярилцлагыг ганцаараа явуулахыг зөвшөөрдөг. Ингэснээр өгөгдсөн хугацаанд илүү олон ярилцлага авах боломжтой. Нөгөө талаар энэ нь ярилцлага өгч байгаа хүний хувьд олон хүнээс сүрдэхгүй, илүү нээлттэй ярилцах боломж олгодог. Гэвч ганц хүний хийсэн ярилцлага агуулга, цар хүрээ, асуудалд бодитой хандах болон аюулгүй байдлын хувьд сул талтай гэдгийг анхаарвал зохино.

Мониторингийн хугацаа

Мониторингийн үргэлжлэх хугацааг уртасгах боломжтой байх нь чухал юм. Ингэснээр ярилцлага болон мониторингийн үед хийгдэх бусад үйл ажиллагаанд хангалттай цаг зориулах боломжтой. Хорих газрын бүхий л үйл ажиллагааг хамарсан цогц мониторингийн үед зарим байгууллагууд томоохон хорих газарт 4 хоног хүртэл хугацаагаар ажилладаг. Мөн түүний оронд богино хугацаатай, дараалсан мониторинг хийх боломж бий.

Мониторингийн давтамж

Өөр нэг хувилбар бол богино хугацаатай мониторинг ойр ойрхон хийх явдал юм. Тухайн хорих газар ойрхон байрладаг тохиолдолд энэ хэлбэр илүү тохиромжтой. Мониторингийн баг нэг удаагийн очилтоор хорих газрын нэг буюу хэд хэдэн хэсэгт эсхүл тодорхой асуудлын хүрээнд мониторинг хийх боломжтой. Ингэснээр уг хорих газарт тодорхой үе шаттайгаар бүрэн хэмжээний мониторинг хийж чадна. Гэнэтийн шалгалт ойр ойрхон хийх нь сөрөг нөлөөг бууруулж, хорихын удирдлагын зүгээс хүний эрхийн нөхцөл байдалд байнга анхаарал хандуулах явдлыг дэмжих сайн талтай. Түүнчлэн, мониторингийн давтамж өссөнөөр хорихын удирдлага ба ажилчид, хоригдлуудтай харилцаагаа бэхжүүлэх, хамтран ажиллах сайхан боломж олгодог.

Мониторингийн бэлтгэл

Хорих газарт очихоос өмнө бэлтгэлээ сайн базааж, холбогдох мэдээллийг авсан байх нь туйлын чухал. Хоригдлуудын жагсаалт, өрөөний байрлал, хорихын ажилтнуудын албан тушаалын дагуух жагсаалт, хоригдлуудын ангилал, тусгаарлах тогтолцоо, хорих газрын план зураг болон бусад мэдээллийг бүрэн авах нь мониторингийн багт нөөц бололцоогоо аль болох бүрэн дүүрэн ашиглах нөхцлийг хангасны үндсэн дээр ярилцлагад оролцох хоригдлуудыг сонгох боломж олгоно.

3. Ганцаарчилсан ярилцлагын нэмэлт аргууд

Хорих газарт эрүү шүүлтээс сэргийлэх мониторинг нь эрүү шүүлт болон бусад байдлаар хэрцгий хандах, хоригдож байгаа хүний нэр төрийг гутаах аливаа үйлдлийг даамжруулж байгаа буюу тэдгээрээс сэргийлж чадахгүй байгаа хүчин зүйлсийг олж илрүүлэх, дүн шинжилгээ хийхэд чиглэдэг. Түүний сацуу тэдгээр эрсдэлт хүчин зүйлсийг системтэйгээр арилгаж, хувь хүн өргөдөл гомдол гаргасан хойно нь биш аль болох урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад гол анхаарлаа хандуулдаг. Тийм ч учраас хоригдлуудтай хийх ганцаарчилсан ярилцлагыг мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх бусад арга, тухайлбал ажиглалт хийх,

баримт бичиг, бүртгэл тооцоог нягтлах, хорихын удирдлуудтай ярилцлага хийх, хууль тогтоомж, бодлого, дүрэм журамд дүн шинжилгээ хийх зэрэг аргатай хослуулан хэрэглэх нь зүйтэй. Эдгээр арга бүгд ганцаарчилсан ярилцлагын агуулга, зорилгыг баяжуулах ач холбогдолтой. Ярилцлагыг үр дүнтэй явуулах дараах боломжийг анхаарахад илүүдэхгүй:

Урьдчилсан асуулга

Зарим байгууллага хорих газарт гэнэтийн мониторинг хийхээсээ өмнө судалгааны асуулга явуулдаг. Асуулгыг тодорхой тооны хоригдлын дунд тарааж, бөглүүлдэг бөгөөд хувь хүмүүсийн ойлголт, туршлагыг тодруулах зорилго агуулдаг. Энэхүү асуулга нь мониторингийн үед анхаарах асуудлыг тодруулах, ганцаарчилсан ярилцлагын хамрах асуултын тоог багасгахад тустай. Гэхдээ энэ аргыг хэрэгжүүлэхэд хоригдлуудын бичиг үсгийн чадвар, нэр хаягийн нууцлал, мэдээллийг боловсруулах хүн хүчний бололцоо зэрэг тодоорхой бэрхшээл тулгарч болно. Хэдий тийм боловч, урьдчилсан асуулга нь ялангуяа жижиг буюу дунд зэргийн хорих газарт хийх мониторингийн үед хэрэглэхэд нэлээд үр дүнтэй арга юм.

Урьдчилсан мониторинг

Урьдчилсан асуулгаас гадна урьдчилсан мониторингийн аргыг ашиглаж болно. Үндсэн мониторинг хийгдэхээс нэлээд хугацааны өмнө тухайн хорихийн талаар ерөнхий ойлголт авах, ямар стареги хэрэглэхээ сонгох зорилгоор энэ аргыг хэрэглэдэг. Урьдчилсан мониторинг нь богино хугацаатай бөгөөд нарийвчилсан шалгалт хийх зорилго агуулдаггүй учраас мониторингийн баг бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцох шаардлагагүй байдгаараа давуу талтай. Түүнээс гадна хорихын удирдлагатай энэ үеэр уулзаж болно. Энэ нь хэлхээ холбоо тогтоох боломж олгохоос гадна мониторингийн баг бүрэн бүрэлдэхүүнээрээ ирсэн үед цаг хэмнэх ач холбогдолтой. Түүний зэрэгцээ урьдчилсан мониторинг нь тухайн хорих газарт мониторинг хийснээс үүдэн хоригдлуудад учирч болзошгүй эрсдлийг шуурхай үнэлэх боломж олгоно. Хэдийгээр урьдчилсан мониторинг хийх гэж байгаа талаар мэдэгдэх нь илүү үр дүнтэй боловч мониторингид үндсэн мониторинг хэзээ хийх тодорхой хуагцааг хорихын удирдлагад мэдэгдэх эсэхээ өөрсдөө шийдэх нь зүйтэй.

Бүлгийн ярилцлага

Мониторинг хийх газартаа бүлгийн ярилцлага хийхээр урьдчилан зохион байгуулах нь тухайн байгууллагын нөхцөл байдал, үйл ажиллагааны талаар ерөнхий мэдээлэл авах чухал хэрэгсэл болдог. Энэ нь ганцаарчилсан ярилцлагын үед хамрах асуудлын тоог багасгах сайн талтай хэдий ч түүнийг орлоно гэсэн хэрэг биш юм. Нөгөө талаар мониторинг хийж байгаа байгууллага ганцаарчилсан ярилцлага явуулах ямар ч боломж байхгүй гэж дүгнэсэн тохиолдолд зөвхөн энэ аргыг хэрэглэх боломжтой.

Мониторингийн эхэнд бүлгийн ярилцлагад оролцогчидтой бэлтгэсэн жагсаалтад байгаа бүх асуултын дагуу ярилцах нь цаашид нягтлах, тодруулах шаардлагатай олон асуудлыг илрүүлэх “халууны шил”-ний үүрэг гүйцэтгэдэг. Хэдийгээр энэ талаар тогтсон хатуу дүрэм журам байхгүй боловч хоригдлуудтай холбоотой халдлага, хүчирхийлэл, айлган сүрдүүлэлт болон бэлгийн хүчирхийлэл зэрэг эмзэг асуудлыг хөндөхдөө болгоомжтой хандах ёстой. Мэдээлэгчдэд учрах эрсдлийг ч мөн анхаарах шаардлагатай. Бүлгийн ярилцлага хийж байгаа зорилгоо ярилцлага эхлэхээс өмнө тайлбарлах нь зүйтэй. Түүний зэрэгцээ ганцаарчилсан ярилцлагын

нэгэн адил нууцыг хадгалах, оролцогчдын зөвшөөрлийг авах, оролцохоос татгалзах боломжтой байх эрэг нөхцлийг хангах нь туйлын чухал.

4. Ганцаарчилсан ярилцлагад оролцох хүмүүсийг сонгох стратеги

Ерөнхий (сэдэвчилсэн бус) урьдчилан сэргийлэх мониторингийн үеэр хийх ярилцлагын старегийг боловсруулах гол зорилго бол тухайн хорихын ерөнхий нөхцлийг төлөөлж чадахуйц, тодорхой бүлэг болон хувь хүмүүст тохиолддог нөхцөл байдлыг тусгасан, шийдвэрлэх шаардлагатай чухал асуудлыг сайтар тодорхойлсон мэдээлэл цуглуулах явдал юм. Энэхүү зорилгод хүрэхийн тулд ярилцлагад оролцогчдыг сонгохдоо дараах 4 ерөнхий аргыг оновчтойгоор хослуулан хэрэглэх нь зүйтэй:

1. Түр зуурын сонголт
2. Асуудалд үндэслэн сонгох
3. Төлөөллийн сонголт
4. Бүгдийг эсхүл хэнийг ч биш сонголт

ТҮР ЗУУРЫН СОНГОЛТ

Дурын сонголт

Мониторингийн баг тухайн хорих газарт очсоныхоо дараа төрсөн сэтгэдэл буюу ажиглалтад тулгуурлан дурын хоригдлыг ярилцлагад оролцуулахаар сонгож болно. Хэрэв уг хоригдол ярилцлага өгөхөөс татгалзвал, түүний сонголтыг хүндэтгэн үзэх нь зүйтэй. Гэсэн хэдий боловч мониторчид тухайн хүн тийнхүү татгалзах болсон шалтгааныг илрүүлэх, түүнийг эрсдэлд оруулахгүйгээр хариу өгөх чадвартай байх ёстой. Энэхүү аргын нэг сул тал бол хорихын удирдлага, ажилтнууд болоод бусад хоригдол тухайн хүнийг тодорхой шалтгааны улмаас сонгосон гэж ойлгох талтай. Энэ нь хоригдлын эсрэг ямар нэг сөрөг арга хэмжээ авахад хүргэж болзошгүй. Тийм ч учраас, мониторчид хорих газарт ажиллах үедээ хорихын удирдлагатай хамт явахгүй байх нь уг эрсдлийг бууруулдаг. Нөгөөтэйгүүр энэ аргыг дангаар нь ашиглах нь асуудлын олон талыг төлөөлж чадах сайн түүвэрлэлт болж чаддаггүй.

Сайн дурынхан

Мониторингийн үед нэг буюу бүлэг хоригдлоос сайн дураараа ярилцлага өгөхийг хүсч болно. Хэдийгээр энэ нь тэднийг бүрэн төлөөлсөн түүвэрлэлт болж чадахгүй ч урьдчилан төлөвлөж, сонгосон бүлгийн өгч чадахгүй чухал мэдээллийг өгөх илүү магадлалтай. Мониторчдын хувьд ганцаарчилсан ярилцлага өгөхийг хүссэн хоригдлуудад цаг гаргаж өгөх нь чухал боловч бүхий л ярилцлагаа зөвхөн сайн дураараа ярилцлага өгөх хүсэлтэй хүмүүст даатгаж болохгүй.

Хорихын удирдлагаас санал болгосон ярилцлага өгөгчид

Мониторингийн үед хорихын удирдлага тодорхой хоригдлуудаас ярилцлага авахыг санал болгох тохиолдол бий. Ерөнхийдөө үүнийг зөвшөөрөх нь зүйтэй боловч мониторингийн багийн баримталж буй стратегиас аль болох гажихгүй байхаар зохион байгуулах нь зүйтэй. Харин хорихын удирдлагын саналыг хүлээж авах нь таатай зүйл биш гэж үзэж байгаа тохиолдолд мониторингийн баг батлагдсан төлөвлөгөөгөө дагах ёстой гэдгээ онцолж, эелдгээр татгалзвал зохино.

АСУУДАЛД ҮНДЭСЛЭН СОНГОХ

Урьдчилан товлосон хувь хүмүүс буюу асуудал

Мониторингийн баг тухайн хорих газарт хүний эрхийн зөрчилд өртсөн буюу өртөх илүү магадлалтай хувь хүмүүс буюу тодорхой тохиолдлын талаар мэдээлэл авсан үед тэдгээр асуудлыг тодруулах зорилгоор ярилцлага хийхийг хүсч болно. Мониторингийн баг эрсдэлд байгаа хувь хүмүүсээс ярилцлага хийхээр урьдчилан товлосон нөхцөлд ч бусад хоригдлуудтай уг ярилцлагын өмнө, хойно, эсхүл тухайн ярицлагатай ойролцоо хугацаанд нэгэн адил ярилцлага хийх нь зүйтэй. Урьдчилан сэргийлэх мониторингийн хувьд тодорхой хэрэг тохиолдлын талаар мэдээлэл цуглуулах гол зорилго бол системтэй зөрчлийг олж тодруулах явдал юм. Хувь хүмүүсийн өргөдөл гомдлыг барагдуулах, хуулийн байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх, эсхүл түүнийг хүлээж авахаас татгалзах зэрэг асуудлыг урьдчилан сэргийлэх мониторингийн үйл ажиллагаанаас ялгаж авч үзэх ёстой.¹

Бүртгэл тооцоо, баримт бичгийг шинжлэн үзэх

Моинторингийн үеэр бүртгэл тооцоо, захиргааны бусад баримт бичгийг шинжлэн үзсэний ачаар ганцаарчилсан ярилцлагаар тодруулах шаардлагатай хэвийн бус буюу ноцтой асуудал, зөрчлийг олж илрүүлэх боломжтой. Холбогдох хоригдлуудаас ярилцлага авах нь мэдээлэл авах гол эх сурвалж болно.

Өмнө нь хоригдож байсан газрын тухай ярилцлага

Мониторчид хорихоос суллагдсан буюу өөр хорихоос шилжиж ирсэн хоригдлоос өмнө нь хоригдож байсан газрынх нь тухай ярилцлага хийж болно. Олон тохиолдолд, ярилцлагад оролцогчид одоо биш харин өмнө нь хоригдож байсан газрынхаа тухай ярихдаа илүү нээлттэй байдаг. Энэ нь ялангуяа тухайн эрх чөлөөгөө хасуулсан этгээд одоогийн хорих газартаа харьцангуй богино хугацаанд хоригдож байгаа, эсхүл уг хорихын тухай ярилцлага хийх боломжгүй тохиолдолд тохиромжтой байдаг. Түүнээс гадна мониторчид хоригдлуудыг нэг хорихоос нөгөөд шилжүүлэн тээвэрлэх үед хүний эрхийн зөрчил ихээхэн гардаг гэдгийг анхаарах ёстой.

ТӨЛӨӨЛЛИЙН СОНГОЛТ

Түүвэр сонголт

Урьдчилан сэргийлэх мониторингийг үр дүнтэй явуулахын тулд эрх чөлөөгөө хасуулан хоригдож байгаа хүмүүсийн үзэл бодлыг төлөөлж чадахуйц түүвэрлэлт хийхэд зориулсан арга зүйд тулгуурлан дээр дурдсан стратегиэс сонгож ашиглах нь зүйтэй. “Санамсаргүй” түүвэрлэлт хийхдээ хэрэв хоригдлуудын нэрсийн жагсаалт цагаан толгойн дэс дараагаар бол тухайн үсгээр эхэлсэн (А, Б, В гэх мэт) нэртэй эхний нэг буюу хоёр хүнийг, эсхүл жагсаалтад байгаа 10 дахь хүн бүрийг сонгож авна. Чухам аль аргыг хэрэглэх нь хоригдлын нийт тоо болон хэдэн ярилцлага хийхээр зорьж байгаагаас шалтгаална. Энэхүү аргыг тухайн хорих газрын онцлог хийгээд бусад практик хүчин зүйлсийг харгалзан өөрчилж болох бөгөөд үүний нэг сул тал бол мониторингийн баг чухам ямар хоригдолтой ярилцлага хийхийг хүсч байгаа тухайгаа хорихын удирдлагад заавал мэдэгдэх шаардлагатай болдог.

¹ See upcoming APT briefings on *What Is Prevention?* and *What Is Preventive Monitoring?*

Нарийвчилсан түүвэр сонголт

Дээр дурдсан аргын илүү боловсронгуй хэлбэр бол хэдийгээр нэмэлт бэлтгэл шаарддаг боловч хоригдлуудын жагсаалтаас мониторингийн багийн сонирхлыг илүү татаж байгаа бүлгийг олж тодорхойлох явдал юм. Тухайлбал, бүх насаараа хоригдох ялтай, өндөр настан, улс төрийн хоригдол, хоригдоод удаагүй байгаа, цөөнхийн бүлгийн, терроризм зэрэг онц ноцтой гэмт хэргээр яллагдагсдыг энэ бүлэгт хамааруулж ойлгож болно. Мониторингийн баг эдгээр бүлгийн онцлог шинжийг тодорхойлсныхоо дараа тэдгээр хоригдлын хэдэн хувиас ярилцлага авахаа шийдсэний үндсэн дээр өмнө дурдсан түүвэр сонголтын аргыг тохируулан хэрэглэж болно. Сонголтын энэхүү арга мониторингийн эхэн хэсэгт хийгддэг бүлгийн ярилцлагад оролцох хүмүүсийг сонгоход мөн тустай.

Дээр дурдсанчлан, урьдчилан сэргийлэх мониторингийн үеэр хийх ярилцлагыг үр дүнтэй явуулахын тулд дээр дурдсан арга барилыг хослуулан хэрэглэх нь зүйтэй.

БҮГДИЙГ ЭСХҮЛ ХЭНИЙГ Ч БИШ СОНГОЛТ

Жижиг цагдаагийн хэлтэс гэх мэт маш цөөн хүнийг хорьж байгаа газарт мониторинг хийхдээ нэг бол тэнд хоригдож байгаа бүх хүнээс ярилцлага авах, эсхүл тэдний хэнтэй нь ч ярилцлага хийхгүй байх нь чухал. Зөвхөн зарим нэг хоригдлоос ярилцлага авах нь тэдний аюулгүй байдалд эрсдэл учруулах магадлалтай. Түүнчлэн, бүх хоригдлыг бөөнөөр нь залхаан цээрлүүлэх тохиолдол гардаг учраас мониторингийн баг тухайн хорих газар, түүний удирдлагатай харилцаж байсан туршлага, дахин уг газарт мониторинг хийх эсэх зэрэг хүчин зүйлст тулгуурлан шийдвэрээ гаргах ёстой.

5. Ярилцлагын стратегийн талаар анхаарах бусад зүйлс

Албан ёсны эсхүл албан бус

Ярилцлага албан ёсны өнгө аястай байх албагүй гэдгийг санаж байхад илүүдэхгүй. Мониторч буюу хоригдлын хэн нь эхэлж санаачилсан байлаа ч амьдрал ахуйн талаар ойр зуурын яриа өрнүүлэх нь мэдээлэл олж авах чухал хэрэглүүр юм. Мониторингийн баг тиймэрхүү боломж гарах үед аль болох эелдэг, хүлээцтэй хандахын зэрэгцээ өөрсдийн болон тэдгээр хоригдлын аюулгүй байдлыг хангахад анхаарах ёстой.

Анхаарах зүйлс

Мониторчид ганцаарчилсан ярилцлагын үеэр чухал мэдээлэл олж авсан тохиолдолд тухайн хоригдлын зөвшөөрлийг авсан, мөн стратегийн хувьд тохиромжтой гэж үзсэнээс бусад нөхцөлд уг мэдээллийг ямар нэг байдлаар гадагш задлах ёсгүй. Аливаа хүний үйл хөдлөл, дохио зангаа ихээхэн зүйлийг илэрхийлдэг ба хорихын ажилтнууд тэдгээрийг мониторингийн туршид төдийгүй мониторинг дуусаад явахад ч анхааралтай ажиглаж байдгийг анхаарах ёстой.

Түүнээс гадна ноцтой мэдээлэл илрүүлсэн даруйдаа тэрхүү мэдээллийг бусад ярилцлагад болгоомжтой бөгөөд тохиромжтой хэлбэрээр нэгтгэн оруулах арга хэмжээ авах нь туйлын чухал. Ижил утгатай мэдээллийг хэд хэдэн эх сурвалжаас авснаа харуулах нь анхны эх сурвалжид зарим нэг хамгаалалт болж чадах хэдий ч гэмгүй хэн нэгнийг буюу эсхүл бүх хоригдлыг түүнээс болж залхаан цээрлүүлэх явдал гарч болзошгүйг байнга анхаарах ёстой.

Залхаан цээрлүүлэх

Мониторингийн ерөнхий стратегид ярилцлагад оролцож байгаа хоригдлууд ба бусад хүмүүсийг залхаан цээрлүүлэлтээс сэргийлэх, тэдэнд учрах эрсдлийг бууруулах бүхий л арга хэмжээг заавал тусгах нь чухал. Ялангуяа анхаарал татахуйц хүний эрхийн нөхцөл байдалтай хорих газруудын хувьд хоригдлуудыг залхаан цээрлүүлэх явдал хаа сайгүй тохиолддог. Мониторингийн баг “хэнд ч хор үл учруулах” зарчмыг мониторинг хийхээс өмнө, хийж байх үедээ болон хийж дууссаны дараа нэгэн адил мөрдөх ёстой. Өмнө дурдсанчлан урьдчилсан мониторинг хийх арга нь болзошгүй эрсдлийг үнэлэх, тэдгээрийг бууруулах талаар стратеги боловсруулах боломж олгодог. Хүлээн зөвшөөрмөөргүй, хянах боломжгүй эрсдэл учирч болзошгүй нөхцөлд хариуцлагатай мониторингийн баг тухайн ярилцлагыг хийхээс татгалзах шийдвэр гаргаж болно.

Түүнээс гадна мониторингийн баг ярилцлагын бүхий л шатанд ярилцлага өгөгчдөд учирч болзошгүй аливаа эрсдэл болон тэдний зөвшөөрлийг авах, итгэмжит байдлыг хадгалахтай холбоотой аливаа асуудлыг бүрэн дүүрэн ойлгуулахад ихээхэн анхаарах ёстой. Ялангуяа ярилцлага өгөх гэж байгаа хүмүүсээс ямар нэг шалтгаанаар уг ярилцлагаас татгалзахыг хүсч байгаа эсэхийг тусгайлан асуух нь зүйтэй. Ингэснээр тэд мониторчидтой хамтран ажиллах эсэх талаар өөрсөддөө ашигтай шийдвэрийг гаргаж чадна.

6. Дүгнэлт

Хорих газарт хийх урьдчилан сэргийлэх мониторингийн үед эрх чөлөөгөө хасуулан тэнд хоригдож байгаа хүмүүсээс чухам хэнийг нь сонгож ярилцлага хийх вэ гэдгээ ул суурьтай тунгаан үзэж шийдвэрлэх шаардлагатай байдаг. Энэ нь хязгаарлдагдмал цаг хугацаа, санхүү, хүн хүчний нөөц бололцоонд тулгуурлан мониторингийн үр дүнг дээшлүүлэхэд тус дөхөм болдог. Ярилцлагад оролцогчдыг хэрхэн сонгох тодорхой стратегитай байх нь тухайн хорих газрын ерөнхий нөхцөл байдал хийгээд эрсдэлт өртөмхий бүлгийнхний нөхцөл байдлыг үнэн бодитой тодорхойлоход ихээхэн ач холбогдолтой. Дээр дурдсан арга барилыг хослуулан хэрэглэх нь энэхүү зорилгод хүрэхэд тус дөхөм болно.

Мониторингийн үеэр хэдий чинээ их чанартай мэдээлэл цуглуулна тэр хэмжээгээр үнэн бодитой дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдэх арга замыг тодорхойлж чадна. Ингэснээр эрх чөлөөгөө хасуулан хоригдож байгаа хүмүүст зохих эрхийг нь эдлүүлэх, тэдэнд эрүү шүүлт тулгах буюу бусад хэлбэрээр хэрцгий хандах явдлаас сэргийлэх, цаашлаад хорих газруудад хүний эрхийг хүндэтгэн сахих явдалд тус дөхөм болно.

